



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭН М.ЧИНГИСХААН ТАНАА

2021.03.01 № 1838
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн иргэн Магнайбаярын Чингисхаан [REDACTED] /-ы сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага нь бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзнэ.

Дүгнэлт

Иргэн Магнайбаярын Чингисхаан /■■■■■■■■■■-ы сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-д тус тус нийцсэн байна.

Иргэн Магнайбаярын Чингисхаан /■■■■■■■■■■-ы сонгуулийн мөрийн хөтөлбөр /...¹⁶..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд



Д.ЗАНДАНБАТ

ЭЦЭГ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДООР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2021 оны 10-р сарын 10-нд
нөхөн сонгуульд БИЕ ДААН оролцох
МОНГОЛ УЛСЫН ИРГЭН
Сартуул овогт магнайбаярын ЧИНГИСХААНЫ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ЭХ ДЭЛХИЙН ХАЙРАН ДЭЭР

13000004

00000018

БИ БИШ БИД

ХҮН ТӨРӨЛХТНИЙ УХАМСАРЫГ СЭРЭЭЖ,
КОРОНА ВИРУСЫГ УСТГАЖ ЧАДНА.

МОНГОЛ ХҮН ДЭЛХИЙН ХҮН ТӨРӨЛХТНИЙ ДАРХЛАА
ГЭДГИЙГ НОТЛОЖ ЧАДНА.

ТӨӨРЧ БУДИЛСАН ХҮН ТӨРӨЛХТӨНД ЗҮГ ЧИГ БОЛЖ,
ХӨГЖЛИЙН ЗӨВ ШИЙДЛЭЭР ҮЛГЭРЛЭЖ ЧАДНА.

НЭГ ДЭЛХИЙ ДЭЭР АМЬДАРЧ БАЙНА

ЭХ ДЭЛХИЙЧДЭЭ
ЭВЭЭ ЭРХЭМЛЭЖ
ХАЙРАА ТҮГЭЭЖ
НЭГДЭЛХИЙ


Нэг:НЭГДЭЛХИЙ

1.1 ЭХ ДЭЛХИЙЧ үзэл баримтлал

1.2 ЭВ ХАЙРЫН бодлого

1.3 АЛТАНГАДАС эко нийслэл хот

Бид бүгд нэг л дэлхий
дээр амьдарч байна



Үндэслэл:

Хүн төрөлхтөн тоотой хэдхэн хүний үзэл сурталын дайнд өртөж, мэдээ мэдээлэл, урлаг соёл, тархи угаалт зэрэг оюуны болоод биологийн зэвсэгээр дайтаж байна.

Энэ цаг үед Монголчууд бид шашин шүтлэг, үзэл суртал, нам засаг, нутаг нуга, жалга довоороо талцаж, хагарч, бутарч болохгүй. Мөн харийн соёлын бодлогод ирээдүй хойч үеийнхээ тархийг угаалгаж бүр ч болохгүй юм.

Жишээ нь барууны кино дуу хөгжим болон Солонгос кино зэрэг нь хэрээс хэтэрч, хойч үед маань буруу үлгэр дуурайлал болж, өөрсдийн үндэсний дархлаагаа алдах аюулд хүрээд байна.

Монголчууд эртнээс эх дэлхийгээ хайрлаж, хамгаалж, хүн төрөлхтний зөв хэмнэл хэвшил хөгжил дэвшил болох ЭКО МИНИМАЛ НҮҮДЭЛЧИН ахуйгаар амьдарсаар ирсэн билээ.

Одоо БИДЭНД
НЭГДМЭЛ НЭГ
ҮЗЭЛ САНАА
ХЭРЭГТЭЙ...



Иймд бид үндэсний язгуур өв соёлын дархлааг дэлгэрүүлж, уламжиллаа орчин үетэй хослуулж хүн төрөлхтний амьдралын ШИНЭ хэмнэлийг шинээр цогцлоож, ЭХ ОРОНЧ гэхээс илүү ЭХ ДЭЛХИЙЧ хэмээх ЭРИН ЦАГИЙН ЭЗЭД БОЛОХ ЁСТОЙ.

ЭВИЙГ ЭРХЭМЛЭЖ, ХАЙРЫГ ТҮГЭЭЖ, хүн төрөлхтөнг байлдан дагуулж, тэднийг үлгэрлэн манлайлж, удирдан залах цаг хаяанд иржээ.

Алсын хараа:

2033 он гэхэд Монголчууд **ЭХ ДЭЛХИЙЧ** үзэл санааны **ТООНО** нь болсон байна. Хүн төрөлхтөн Эх дэлхийгээ хайрлан хамгаалах үзэл санаанд эвлэн нэгдэж, Монголчуудын орчин үеийн **ЭКО МИНИМАЛ** амьдралын зөв хэмнэл хэвшлийг даган дуурайж, **ЭХ ДЭЛХИЙЧ ХҮН** болохыг зорих болно.

Мөн **ЭВ ХАЙРЫН** бодлого бүрэн хэрэгжиж **АЛТАН ГАДАС** хэмээх **эко нийслэл** хүн төрөлхтөний хөгжил дэвшлийн зөв зүг чигийг доторхойлж, дэлхийн улс хотуудын үлгэрлэл болж, Монгол улсад сүндэрлэсэн байна.



Өндөр уулын хөтөл зорь
Өргөн далайн олом зорь

Эрхэм зорилго:

Байгаль эх дэлхийтэй буруу бусармаг харьцаж, хүсэл шунал дачаалдаа дарагдаж, чөтгөрийн эрхшээлд автсан хүн дүрст чөтгөрүүдэд эцэг тэнгэрийн ГЭСГЭЭЛ үзүүлж, хүн төрөлхтөнг шигшиж, тунгааж цэнзүүрлэж, ижий дэлхийгээ хайрлан хамгаалах эрхэм үүргийг ухааруулж, ЭХ ДЭЛХИЙЧ ХҮН ТӨРӨЛХТӨНГ бүтээхэд бидний эрхэм зорилго оршив.


Үнэт зүйл:

Эх дэлхий, ирээдүй хойч үе, эх дэлхийч хүн, үндэс язгуур өв соёл, тал дүүрэн мал, танан цагаан гэрүүд бидний хамгийн үнэт зүйл мөн.



Давашгүй даваа бий гэнэм
Хэрхэн давах вэ? гэж бүү цөх
Давъя хэмээвээс давна.

Гэтлэшгүй мөрөн бий гэнэм
Хэрхэн гэтлэх вэ? гэж бүү цөх
Гэтлье хэмээвээс гэтлэнэ.



ЭХ ДЭЛХИЙЧ үзэл гэдэг нь:

Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, өөртөө болон өрөөл бусдад, ан амьтан, байгаль дэлхийд хор хөнөөлгүй амьдарч, шашин шүтлэг, үзэл бодол, нас хүйс, царай зүс, арьс өнгө зэрэгээр үл ялгаж, бүгд энх тайван эрх тэгш амьдрах нэгдмэл нэг ҮЗЭЛ САНААНЫ ЭХ юм. Монголчууд хүн төрөлхтөнд үлгэрлэнэ.

Бид НЭГ л ДЭЛХИЙ дээр АМЬДАРЧ байна.

1.1.1 ЭХ ДЭЛХИЙЧ хүний эрхэмлэх ЕСөн ЁС

- 1.1.1.1 Агаар, ус бохирдуулахгүй, газар дэлхийг сэндийчихгүй байх
- 1.1.1.2 Амьд бүхнийг хүндлэж, хайрлан хамгаалж байх
- 1.1.1.3 Алаг дэлхий болоод нар, сар, одод тэнгэрт талархаж байх
- 1.1.1.4 Хүний амь хөнөөхгүй байх
- 1.1.1.5 Хүнлэг бус зан чанар гаргахгүй байх
- 1.1.1.6 Хүйтэн хөндий харилцаа хандлагагүй байх
- 1.1.1.7 Архи, тамхи, химийн гаралтай мансуурах бодис хэрэглэхгүй байх
- 1.1.1.8 Авлигал хээл хахуульд өртөхгүй өгөхгүй авахгүй байх
- 1.1.1.9 Амин мөн чанартай үнэн байж, ухамсар өндөр ухаантай байх ЁСТОЙ.

1.1.2 ЭХ ДЭЛХИЙЧ ЭМ хүний эрхэмлэх ЕСөн ЁС

- 1.1.2.1 Сэтгэл, санаа, бие цогцосыг цэвэр ариун байлгах
- 1.1.2.2 Сэцэн саруул сэргэг цовоо эртэч энэрэнгүй байх
- 1.1.2.3 Сэтгэл хувааж талцал бутрал үүсгэхгүй байх
- 1.1.2.4 Үр хөндүүлэхгүй, үг болоод үйлдэл зөв байх
- 1.1.2.5 Үр хүүхэддээ үнэн зөв үлгэрлэж ЭХ ДЭЛХИЙЧ хүн болгох
- 1.1.2.6 Үндэс язгуур өв соёлоо үр хойчдоо өвлүүлж түгээж байх
- 1.1.2.7 Эр хүнийг эцэгийн адил хүндэтгэж хайрлаж байх
- 1.1.2.8 Эргэн тойрондоо гэрэл гэгээ түгээж цэвэр цэмцгэр байх
- 1.1.2.9 Эхийн сав ертөнцийг ариун дагшин байлгах нь хамгийн эрхэм ЁС юм.

1.1.3 ЭХ ДЭЛХИЙЧ хүүхдийн эрхэмлэх ЕСөн ЁС

- 1.1.3.1 Эцэг эх байгаль дэлхийгээ хүндлэн хайрлаж байх
- 1.1.3.2 Эргэн тойрондоо хог хаяхгүй цэвэр цэмцгэр байх
- 1.1.3.3 Эмээ өвөөдөө туслаж, өв соёлоо судлаж, суралцаж байх
- 1.1.3.4 Анд нөхөд ах дүүдээ хүндлэлтэй, ач тусыг хариулж байх
- 1.1.3.5 Ачит багш сурган хүмүүнжүүлэгчээ хүндлэж, зөв сурагч байх
- 1.1.3.6 Амин дэмтэй хоол хүнс хэрэглэж, дасгал хөдөлгөөн хийж байх
- 1.1.3.7 Мөрөөдөл зорилго тэмүүлэл нь зөв зүйтэй байх
- 1.1.3.8 Мөнх бус амьдралыг ажаргал инээд баяслаар дүүрэн байлгах
- 1.1.3.9 Хань ижил хайр сэтгэлдээ хариуцлагатай хандах ЁСТОЙ.

1.1.4 ЭХ ДЭЛХИЙЧ ЭР хүний эрхэмлэх ЕСөн ЁС

- 1.1.4.1 Эх дэлхий, эх орон, гэр бүл орчин тойрондоо эзэн байх
- 1.1.4.2 Эвийг эрхэмлэж, хайрыг түгээж байх
- 1.1.4.3 Эрдэм номтой эрүүл чийрэг эрч хүчтэй байх
- 1.1.4.4 Байгалийн хуулийг судлан суралцаж, амьдралын зөв зуршил болгох
- 1.1.4.5 Бүх цаг үед тулгарсан асуудлыг шийдэж чаддаг байх
- 1.1.4.6 Бодлоготой үг, үйлдэл гаргахгүй өв тэгш, төв цэгц байх
- 1.1.4.7 Мал аж ахуй, газар тариалан эрхлэдэг байх
- 1.1.4.8 Мөнгө санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн байх
- 1.1.4.9 Мөнх бус амьдрах учир бүх зүйлд талархаж хүндлэж хайрлаж байх

УИХ-д орвол 4 жилийн хугацаанд юу хийх вэ?

ЭХ ДЭЛХИЙЧ үзэл санааны 7 эгшиг хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- 1.1. А СӨБ болон ЕБС-д ЭХ ДЭЛХИЙЧ үзэл санааны хичээл сургалтыг хөтөлбөржүүлэн суулгана
- 1.1. Э Сургах арга зүй нь хөгжөөнт хэлбэрээр байх ба хүүхдийг залхаан цээрлүүлэхийг хориглоно.
- 1.1. И Хичээлээс гадуур амрал чөлөөт цагт нь тааруулж, байгал эх дэлхийд аялуулана.
- 1.1. О Олон нийтийн мэдээллийн сувагуудаар ЭХ ДЭЛХИЙЧ контентууд нэвтрүүлэнэ.
- 1.1. У ЭХ ДЭЛХИЙЧИД клубыг нас насны ангилалаар аймаг, сум дүүрэг бүрт нээнэ.
- 1.1. Ө ЭХ ДЭЛХИЙЧ хүүхдийн зуслан, гэр бүлийн амралтын бааз зэргийг бүх нийтэд хүртээмжтэйгээр нээнэ.
- 1.1. Ү ЭХ ДЭЛХИЙЧ үзэл санааны ХУУЛЬ санаачлан олон нийтээр хэлэлцэж батлуулна.

МӨНГӨЛ АРДЫН УРААДААНТ, ЦЭНГЭЭНТ. ТАНИН МЭДЭХҮЙН ЦУВРАЛ НЭВТРҮҮЛЭГЧ

Хувийн дүрсэр №04 Б. ТЭМҮҮЛЭН
Хувийн дүрсэр №07 Ц. ДАВААБАЯР
Хувийн дүрсэр №08 С. ХАЛИУН
Хувийн дүрсэр №09 Т. ХАТАНЗОРИГ
Хувийн дүрсэр №10 Б. ХУЛАН
Хувийн дүрсэр №11 О. БҮРЭНЗАЯА
Хувийн дүрсэр №12 Г. ТЭМҮҮЛЭН
Хувийн дүрсэр №13 Н. НОМИН
Хувийн дүрсэр №14 А. ЭНЭРЭЛ-ОД
Хувийн дүрсэр №15 Г. БАЯРДЭЛГЭР
Хувийн дүрсэр №16 Г. АНХБАЯР
Хувийн дүрсэр №18 Б. ЗУЛАА

ntv Даваа, Лхагва, Баасан 18:30 -оос
Даваа, Мянгар, Пүрэв 12:10 -оос
ХЭЛБЭР АГУУЛА БҮТЭЭГЧ

Мөн milk ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ

СМС 152015

ХЭЛБЭР АГУУЛА БҮТЭЭГЧ МОНГОЛ TV ТУН УДАХГҮЙ... ХЭЛБЭР АГУУЛА БҮТЭЭГЧ

ХЭЛБЭР АГУУЛА БҮТЭЭГЧ МОНГОЛ TV ТУН УДАХГҮЙ... ХЭЛБЭР АГУУЛА БҮТЭЭГЧ

MONGOLIAN ETHNIC COGNITIVE COMPETING IN REALITY TV SHOW

МЭДЭХҮЙ:

Гараг эрхэс, Нар, Сар, Дэлхий бүгд тойрог хэлбэрт оршин байдаг.


Монгол хүн ГЭРийг байгал ертөнцийн хуулийн дагуу бүтээсэн УХААНТАН билээ.

Монгол ГЭР бол гэгээрлийн орон зай, орчлон ертөнцийн тогтолцоо, байгал дэлхий юм.

Тиймээс бид Монгол гэрээрээ бахархаж, үнэ цэнийг нь мэдэрч, ГЭР хэмээх байгалд ээлтэй ЕСО орон сууцаа шинэчилж, дэлхийд зөв таниулан тамгалах цаг нь болжээ.

Учир нь хүн төрөлхтөн байгал ертөнцийн хуулиас гажууд амьдарч байна.

ГЭР УХААН бол ЭВ ХАЙР юм.



ЭВ ХАЙРЫН БОДЛОГО гэдэг нь:

Дэлхийн хүн төрөлхтөнг Монгол үндэсний язгуур өв соёлоор засаж, засаглах, ЭВИЙГ ЭРХЭМЛЭХ, ХАЙРЫГ ТҮГЭЭХ зөөлөн хүчний бодлого юм. Дэлхийг Монгол ГЭР гэж үзвэл ТООНО нь Монгол билээ.

ХҮН төрөлхтөн НЭГ Л ГЭРТ амьдрах БАЙНА.

УИХ-д орвол 4 жилийн хугацаанд юу хийх вэ?

1.2.1 Урлаг бол Улс төрийн бодлого юм.

1.2.1.1 YOUTUBE-д 8 тэрбум үзэлттэй MONGOLIAN STAR-ийг төрийн бодлоготойгоор төрүүлнэ.


1.2.1.2 МОНГОЛ КИНО УРЛАГ-ийг төрөөс дэмжиж, ОСКАР-ын шагналыг авна.

1.2.1.3 ЭВ ХАЙР-ын өдөрлөг жил бүр зохион байгуулна.

1.2.1.4 Хөлбөмбөгийн зүлгэн дээр бөхчүүдийг барилдуулахгүй.
"МОНГОЛ НААДАМ" үндэсний цэнгэлдэх хүрээлэнг шинээр цогцлооно.

1.2.1.5 Монголын Хүүхдийн УСК, Монголын Үндэсний Олон ангит УСК-г төрөөс бодлоготойгоор дэмжиж, ард иргэд болоод хүн төрөлхтөнд Монгол үндэсний соёлыг таниулан сурталчилж гадаадын улс орнуудад худалдаалж, ашиг орлого олохоос гадна. Аялал жуулчлалыг өөрсөддөө татна.

Жишээ нь:



УИХ-д орвол 4 жилийн хугацаанд юу хийх вэ?

1.2.2 11-тийн систем болох “ГЭР11” системийг хэрэгжүүлнэ.

1.2.2.1 Гэр хорооллын айл өрхүүдэд хөршийн холбоо үүсгэж, хуучин хашаанд нь хувьсгал хийх болно. 11 айл дундаа авто машины зогсоол, гүний худаг, хүүхдийн тоглох талбай, ахмадын амрах газар, залуусын болзох, чөлөөт цагаа өнгөрүүлэх спортын талбайтай гэх мэт эрүүл цэвэр тохилог аюулгүй ажаргалтай орчинг бүрдүүлж, машин, дугуйн, явган хүний зам, ариун цэврийн өрөө зэрэгт илүү анхаарч гэр хороололд **СТАНДАРТ** тогтоох болно.

1.2.2.2 Уламжлалт Монгол гэрийг орчин үетэй хослуулж, шинэчилэн төгөлдөршүүлж 21-р зууны суурин МОНГОЛ ГЭР-ийг бүтээх юм. **АХУЙ АНХДАГЧ**



УИХ-д орвол 4 жилийн хугацаанд юу хийх вэ?

1.2.3 Дэлхийн томоохон цэвэр усны БРЭНД “ХАЙР LOVE” УЛСЫН УСНЫ ҮЙЛДВЭРИЙГ САНААЧЛАН БҮХ АРД ТҮМНЭЭРЭЭ НЭГДЭЖ БАЙГУУЛАХ БОЛНО.

Бид газар дээрх баялагаа үл анзааран газар доорх баялагт улайран шунацгааж, байгал дэлхийгээ ухаж төнхөж, уул ус газар шороотой ёс бусаар харьцаж байна. Монголчууд бидэнд баяжих маш олон боломж буй за.

Түүний нэг жишээ бол цэвэр ус билээ. Дэлхийд цэвэр усаараа дээгүүрт байдаг Монголчууд бид алтнаас ч үнэтэй цэвэр усаа үнэлэж, үнэ цэнийг нь мэдэж, мэдрэх цаг нь хэдийнэ болжээ.

Бид байгалиасаа ундрал булиглаж буй булгийн ус рашаанаа стандартын дагуу савлахад л дэлхийн зах зээлд гаргах бүтээгдэхүүнтэй болох боломжтой.

**БҮХ АРД ТҮМНЭЭРЭЭ НЭГДЭЖ,
НЭГЭН ТОМ УС САВЛАГААНЫ
УЛСЫН УСНЫ
ҮЙЛВЭРТЭЙ БОЛЦГООЁ.**

УС АЛТНААС ҮНЭТЭЙ !

**УУЛ, УС, ГОЛ, МӨРӨН, БУЛАГ ШАНДАА ХАМГААЛАХ,
ХОГ ЦЭВЭРЛЭХ, МОД БУТ ТАРИХ ЗЭРЭГ ХӨДӨЛГӨӨН
АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ БҮХ НИЙТЭЭР
ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.**



1.3 АЛТАН ГАДАС эко нийслэл

МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2021–2024
Магнайбаярын ЧИНГИСХААН

Алсын хараа:

Бусад улс үндэстний ажиллаж амьдран сууршихыг хүсдэг мөрөөдлийн хот болно.

Эрхэм зорилго:

Хүн төрөлхтөнд үлгэрлэн манлайлж, тэднийг удирдан залах, ЭХ ДЭЛХИЙЧ хүмүүсийн эх дэлхийдээ эзлтэй, ан амьтан хүнд төрөлхтөнд хоргүй инээд баясал, энх тайван, эв хайраар ундарсан аялал жуулчлалын хот байна.

Үнэт зүйл:

Эх дэлхийч хүмүүн энэ хотын үнэ цэнэ билээ.

Уриа үг:

Ээж дэлхийдээ бид хайртай...



1.3 АЛТАН ГАДАС эко нийслэл

МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2021–2024
Магнайбаярын ЧИНГИСХААН

УИХ-д орвол 4 жилийн хугацаанд юу хийх вэ?


1.3.1 АЛТАН ГАДАС хотын шав тавих ёслол

1.3.2 Макет загвар хот бүтээнэ

1.3.3 Дэлхийн зах зээлээс хөрөнгө босгоно

Нэг сая айл өрхтэй
АЛТАН ГАДАС нийслэлийн
Ерөнхий бүтэц

10 дагуул нийслэлэй
11-тийн системээр...



УИХ-д орвол 4 жилийн хугацаанд юу хийх вэ?

СЭТГЭЛГЭЭНИЙ ХУВЬСГАЛ ХИЙНЭ ЗАЛУУСТ ҮЛГЭРЛЭНЭ

